



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2021/67/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033

Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805

Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955

Цахим хаяг: Gantuya.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан .....	5
3.1. Ерөнхий зүйл.....	5
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	5
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	5
3.4. Материаллаг байдал .....	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	7
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт .....	9
Залруулсан алдаа .....	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	9
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	10
4. Менежментийн захидал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	11

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 81

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БЯАН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ш.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баян-өндөр сумын ЗДТГ-ын дарга Ш.Өлзийбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шаардах хуудсыг /НХМаягт БМ-4/-аар бүрэн хөтөлж, дугаарлах, бараа материал хүссэн албан хаагчдаар шаардах хуудсыг бичүүлж, материалыг олгож байх, хамтран ажиллах гэрээг дүгнэж, тайланг авч баримтанд хавсаргаж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 3/111 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баян-өндөр сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Сумын нийгэм эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх, шуурхай удирдлагаар хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Баян-өндөр сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-өндөр сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,869,408.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,694.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн (ОРА-2021/67/СТА-ТШЗ)

санхүүгийн тайлангийн нийт орлого 6,202,769.8 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул 1 хувиар буюу 62,027.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,617,125.3 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,000.0		-7,000.0
Авлага	200,794.9	4,500.0	-196,294.9
Урьдчилгаа			
Бараа материал	163,808.0	96,671.6	-67,136.4
Үндсэн хөрөнгө	4,914,248.8	7,801,805.6	2,887,556.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,285,851.9</b>	<b>7,902,977.2</b>	<b>2,617,125.3</b>
Өр төлбөр	900.0	4,500.0	3,600.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,284,951.9	7,898,477.2	2,613,525.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,285,851.9</b>	<b>7,902,977.2</b>	<b>2,617,125.3</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7000.0 мянган төгрөг байснаас үлдэгдэлгүй болж буурсан байна. Энэ нь ахмадын сангийн 7,000.0 мянган төгрөгийн үлдэгдлийг байгууллагын 38 ахмадад сар шинийн баяраар 1,330.0 мянган төгрөг, рашаан сувиллалын зардалд 4,560.0 мянган төгрөгийг, ахмадын баяраар 1110.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгож мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй болсон байна.

Авлага дансны үлдэгдэл 200,794.9 мянган төгрөг байснаас 4,500.0 мянган төгрөг болж 196,294.9 мянган төгрөгөөр буурсан нь эрдэнэтчүүд хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж гэрээний үүргийн биелэлтийг хангаж иргэдэд хөрөнгийг шилжүүлж 196,294.9 мянган төгрөгийн авлага буурсан байна. Авлага дансны үлдэгдэлд байгаа 4500.0 мянган төгрөг нь 2020 оны 12 сарын 22-нд ХГБЗГ-аас эмзэг бүлгийн хүүхдийн судалгааны зардалд зориулагдсан санхүүжилт байсан нь тухайн онд судалгаа хийгдээгүй тул үлдэгдлээр үлдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,671.6 мянган төгрөг болж 67,136.4 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалаас 18,389.8 мянган төгрөг, аж ахуйн материалаас 79,230.5 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын тушаалаар акталж данснаас хассанаас шалтгаалсан байна.

Тусгай зориулалтын материалд ДЗОУБ-аас 7078.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, Баян-өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангаас бэлтгэсэн 21,726.8 мянган төгрөгийн материал, аж ахуйн 90,961.7 мянган төгрөгийн материал, бусад хангамжийн материалд 50,000.0 мянган төгрөгийн өвс бэлтгэсэн, түлш шатах тослох материалд 2519.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг тус бүр орлогод авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,801,805.6 мянган төгрөг болж 2,887,556.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дансанд өөрийн хөрөнгөөр 664.9 мянган төгрөгөөр дарга сандал, Согоот, Даваат, Уртын гол багуудад БХДХ-ийн зардлаар хурлын ширээ, сандал, шкаф зэргийг 2124.9 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Аймгийн Орон нутгийн

өмчийн газраас 1,672,032.1 мянган төгрөгийн Эрдэнэ багийн төвийн цогцолбор барилга, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилт, аймаг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 729.1 мянган төгрөгийн 16 тоглоомын талбай, улсын нөөцийн газраас 36,000.0 мянган төгрөгийн пургон авто машин, Эрдэнэ багийн цогцолбор байрны тохижилтын тоног төхөөрөмж 395.0 мянган төгрөг, 87,348.3 мянган төгрөгийн гадна сандал, вакуум цонх, хаалганууд, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 29,080.8 мянган төгрөгийн сургалтын самбар, хуванцар сандал, том жижиг ширээнүүдийг тавилга эд хогшилд, Рашаант, Говил, Даваат, Яргуйт, Уртын гол, Цагаанчулуут багуудад усны хаялгыг зам гүүрийн байгууламжид, Зэст, Яргуйт, Дэнж багуудын байрны 117,886.0 мянган төгрөгийн газрыг биет бус хөрөнгөд тус бүр орлогод бүртгэсэн байна.

Говил, Булаг, Дэнж, Наран багуудад 52,523.9 мянган төгрөгийн үнэтэй хүүхдийн тоглоомын талбай хотын дахин төлөвлөлтөд орсон тул данснаас хассан. Төмөр замын 3-р байрны 1-р блокын дээвэр засварын ажлыг гүйцэтгэлээр орлогод авч мөн өдрөөр зарлагадсан байна. Баян-өндөр сумын албан хэрэгцээнд ашиглаж байсан 58,390.0 мянган төгрөгийн үнэтэй 4 тээврийн хэрэгслийг авто тээврийн үндэсний төвийн акт, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоос 1,499.8 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан суурин компьютерийг, 1,955.6 мянган төгрөгийн үнэтэй ширээ сандалыг тус бүр акталж данснаас хассан байна. Харин Жаргалант суманд ашиглаж буй 5,209.5 мянган төгрөгийн 3 ширхэг компьютерийг балансаас баланс хооронд шилжүүлсэн.

2020 оны санхүүгийн тайланд биет бус хөрөнгөд Зэст, Яргуйт, Дэнж багуудын байрны газрыг бүртгэж 117,886.0 мянган төгрөгөөр өссөн байна. Өр төлбөр дансанд богино хугацаат 4,500.0 мянган төгрөгийн эмзэг бүлгийн хүүхдийн кейс судалгааны төлбөр бүртгэгдэж өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,898,477.2 мянган төгрөг болж тайлант оны үр дүн 2,495,639.3 мянган төгрөг, биет бус хөрөнгийн 117,886.0 мянган төгрөгөөр өссөн байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6,202,769.8 мянган төгрөгөөр буюу 55 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 375,434.2 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин 145,734.8 мянган төгрөг, НДШ 18,337.0 мянган төгрөг, байр ашиглалтын зардал 13,895.4 мянган төгрөгөөр зардлууд өссөн байна. Энэ нь МУ-ын Засгийн газрын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 сараас цалин нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжих 2,629,946.2 мянган төгрөг, нийт зарлагыг 2,629,946.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 279,210.7 мянган төгрөгөөр бууруулж нийт зардлыг 2,350,735.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,350,735.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,350,735.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,350,735.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,336,710.5 мянган төгрөгийг зарцуулж, 14,025.0 мянган төгрөгийн зардлын хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын хэмнэлт 14,025.0 мянган төгрөг буюу 0.6 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 4.4 мянган төгрөг, НДШ-ийн зардлыг 14,013.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 7.5 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 31,004.0 мянган төгрөг, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжүүлэх зардалд 44,000.0 мянган төгрөг, багийн судалгааны ажилтнуудын цалин, НДШ-ийн зардалд 125,848.8 мянган төгрөг, эрх зүйн хөтөчийн урамшуулалд 45,743.2 мянган төгрөг, багийн хэсгийн ахлагч нарын шуудан холбоо, бичиг хэргийн зардалд 28,800.0 мянган төгрөг, эко жорлонгийн үлдэгдэл санхүүжилт 7,427.7 мянган төгрөг, хүн ам орон сууцны тооллогын зардал 44,335.2 мянган төгрөг, эмзэг бүлгийн хүүхдийн кейс судалгааны зардал 4,500.0 мянган төгрөг, нийт 331,658.9 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн орлогоор 17,742.0 мянган төгрөг, нийт 349,400.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулах 149 мэдээллээс 21 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 11 мэдээллийг огт байршуулаагүй байна. Үүнд: Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн 10,11,12 сарыг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 11 сарыг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 9,10,11 сарыг, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн 10, 11 сарын мэдээллийг огт мэдээлээгүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Зөрүү
----------	---------------------	---------	-------

Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2		2				
Албан шаардлага	1		1				
Зөвлөмж	2		2				
Нийт дүн	5		5				

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 63,792.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 56,841.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,264.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,686.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайланд бусад хөрөнгийг 11,310.2 мянган төгрөгөөр илүү, бараа материалын тодруулга тайлангийн аж ахуйн материалаас 45,531.3 мянган төгрөгийн материалыг акталсныг дутуу бүртгэснийг тус тус залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 6,950.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,264.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5686.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Авто юнайтэд ХХК-аас 2020.12.18-ны өдрийн 00656 төлбөрийн хүсэлтээр 3,605.4 мянган төгрөгийн авто машины сэлбэг худалдан авснаас 1,144.7 мянган төгрөг, Анхлан-аз ХХК-аас 1,214.1 мянган төгрөгийн барилгын материал худалдан авснаас 120.0 мянган төгрөг, нийт 1264.7 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд бүртгэж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Байгууллагын даргын 2020.09.21-ний өдрийн Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай Б/172 дугаар тушаалаар 7, 8 саруудад амарсан 12 албан хаагчдад ур чадварын нэмэгдэл 25%-иар 1,686.0 мянган төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Шилэн дансанд байршуулах 149 мэдээллээс 21 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 11 мэдээллийг огт байршуулаагүй байна. Үүнд: Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн 10,11,12 сарыг, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 11 сарыг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 9,10,11 сарыг, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн 10, 11 сарын мэдээллүүдийг огт мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Цалинг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын тайланд нэхэмлэх хуудсыг үндэслэн орлогын баримтаар бараа материалыг орлогод авах байтал нэхэмжлэх хуудсыг канондож хийсэн, шаардах хуудсыг хүчингүй болсон маягтаар хөтөлсөн, дугаарлаагүй, тухайн хэрэгцээт материал авах хүнээр шаардах хуудсаа бичүүлдэггүй, нярав өөрөө шаардах хуудсаа бичдэг зөрчлүүд илэрсэн байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны 347 дугаар тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах тухай" зааврын дагуу шаардах хуудсыг /НХМаягт БМ-4-аар/ бүрэн хөтөлж, дугаарлах, бараа материал хүссэн албан хаагчдаар шаардах хуудсыг бичүүлж, материалыг олгож байх.

Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Баян-өндөр сумын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллээр нэвтрүүлэг, шторк бэлтгэх түүнийг архивын материал болгон хүлээлгэж өгөхөөр хэвлэл мэдээллийн 10 байгууллагатай 2020.03.19-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж 2020.12.21-ний өдөр байгууллага бүрт 1,000.0 мянган төгрөг буюу нийт 10,000.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн ч 4 байгууллагын анхан шатны баримт болох гэрээний биелэлтийг дүгнэсэн акт болон гэрээгээр гүйцэтгэсэн ажлын тайлан ирүүлээгүй зөрчил илэрсэн байна.

2.2. Эрсдэл:


Хамтран ажиллах гэрээний хэрэгжилт хангагдахгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." заалтыг хэрэгжүүлэн хамтран ажиллах гэрээг дүгнэж, тайланг авч баримтанд хавсаргаж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Баян-өндөр сумын ЗДТГ-т өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.02.25-ны 3/317 тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

	АУДИТЫН ТАЙЛАНГ		
<u>ХЯНАСАН:</u> ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРМАНДАХ	Огноо:
АУДИТЫН МЕНЕЖЕР		Б.ЭРДЭНЭ	Огноо:
<u>БЭЛТГЭСЭН:</u> АУДИТОР		О.ГАНТУЯА	

(ОРА-2021/67/СТА-ТШЗ)

10

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			САГ-2021/67/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Баян-өндөр сумын Засаг даргын Тамгын газар</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын тайланд нэхэмлэх хуудсыг үндэслэн орлогын баримтаар бараа материалыг орлогод авах байтал нэхэмжлэх хуудсыг канондож хийсэн, шаардах хуудсыг хүчингүй болсон маягтаар хөтөлсөн, дугаарлаагүй, тухайн хэрэгцээт материал авах хүнээр шаардах хуудсаа бичүүлдэггүй, нярав өөрөө шаардах хуудсаа бичдэг зөрчлүүд илэрсэн байна.		Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ш.Өлзийбаяр, А.Адъяадолжин
2	Баян-өндөр сумын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллээр нэвтрүүлэг, шторк бэлтгэх түүнийг архивын материал болгон хүлээлгэж өгөхөөр хэвлэл мэдээллийн 10 байгууллагатай 2020.03.19-ний өдөр хамтран ажиллах гэрээ байгуулж 2020.12.21-ний өдөр байгууллага бүрт 1,000.0 мянган төгрөг буюу нийт 10,000.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн ч 4 байгууллагын анхан шатны баримт болох гэрээний биелэлтийг дүгнэсэн акт болон гэрээгээр гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй зөрчил илэрсэн байна.	4,000.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ш.Өлзийбаяр, А.Адъяадолжин
3	Авто юнайтэд ХХК-аас 2020.12.18-ны өдрийн 00656 төлбөрийн хүсэлтээр 3,605.4 мянган төгрөгийн авто машины сэлбэг худалдан авснаас 1,144.7 мянган төгрөг, Анхлан-аз ХХК-аас 1,214.1 мянган төгрөгийн барилгын материал худалдан авснаас 120.0 мянган төгрөг нийт 1264.7 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд бүртгэж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	1,264.7	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ш.Өлзийбаяр, А.Адъяадолжин
4	Байгууллагын даргын 2020.09.21-ний өдрийн Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай Б/172 дугаар тушаалаар 7, 8 саруудад амарсан 12 албан хаагчдад ур чадварын нэмэгдэл 25%-иар 1,686.0 мянган төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1,686.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ш.Өлзийбаяр, А.Адъяадолжин

**Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5	Шилэн дансанд байршуулах 149 мэдээллээс 21 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 11 мэдээллийг огт байршуулаагүй байна. Үүнд: Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн 10,11,12 сарыг, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 11 сарыг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 9,10,11 сарыг, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн 10, 11 сарын мэдээллүүдийг огт мэдээлээгүй байна.		Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ш.Өлзийбаяр, А.Адъяадолжин
<b>ДҮН</b>		6,950.7		Албан шаардлага	

ХЯНАСАН:  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР



Ц.НАРМАНДАХ  
Б.ЭРДЭНЭ  
О.ГАНТУЯА

Огноо:  
Огноо:



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 93/93 ОРА-2021/02/СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын 2020.09.21-ний өдрийн Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай Б/172 дугаар тушаалаар 7, 8 саруудад амарсан 12 албан хаагчдад ур чадварын нэмэгдэл 25%-иар 1,686.0 мянган төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-өндөр сумын ЗДТГ-ын дарга Ш.Өлзийбаяр, нягтлан бодогч А.Адъяадолжин нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 94/94 ОАА-2021/02/СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд байршуулах 149 мэдээллээс 21 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 11 мэдээллийг огт байршуулаагүй байна. Үүнд: Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн 10,11,12 сарын, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн 11 сарын, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 9,10,11 сарын, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн 10, 11 сарын мэдээллүүдийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.2.4-т “хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын

4.2.1.11-д "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу сайтад мэдээллийг хоцроож, дутуу мэдээлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-өндөр сумын ЗДТГ-ын дарга Ш.Өлзийбаяр, нягтлан бодогч А.Адъяадолжин нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 сарын 4 өдөр

Дугаар 0050 ОА-2021/67/СТА-ТШЗ

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баян-өндөр сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авто юнайтэд ХХК-аас 2020.12.18-ны өдрийн 00656 төлбөрийн хүсэлтээр 3,605.4 мянган төгрөгийн авто машины сэлбэг худалдан авснаас 1,144.7 мянган төгрөг, Анхлан-аз ХХК-аас 1,214.1 мянган төгрөгийн барилгын материал худалдан авснаас 120.0 мянган төгрөг, нийт 1264.7 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд бүртгэж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13.1-т "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "төрийн аудитын тухай хуулийн 21-р зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баян-өндөр сумын ЗДТГ-ын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 1,264.7 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Баян-өндөр сумын ЗДТГ-ын дарга Ш.Өлзийбаяр, нягтлан бодогч А.Адъяадолжин нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... О.ГАНТУЯА

<sup>1</sup> Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955